



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Н.ГАНБЯМБА ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2019.02.27 № 05/1836
танай 2019.02.15-ны № 9/258 -т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлгийг хянасан тухай

Хэнтий аймгийн Баян-Адарга сумын цэцэрлэгийн эрхлэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Сандагийн Өнөрцэцэгийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд зүйлд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

Түүнчлэн нэр дэвшигч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахыг анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР *Х.ХАШБААТАР*



0003287